



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 02 сарын 19 өдөр

Дугаар 46

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Цэвэр бохир усны итгэмжлэгдсэн болон зөөврийн лаборатори байгуулах” төсөл, арга хэмжээний хүрээнд нийлүүлсэн нийт 44,055,000.00 (дөчин дөрвөн сая тавин таван мянган) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Дулаан шарын гол” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайхан, “Дулаан шарын гол” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Энхцэцэг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.


3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ГАНБАТ

БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.БАЯР-ЭРДЭНЭ

0000077

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 02 дугаар сарын 19 -ний өдрийн
46... дугаар тогтоолын хавсралт

"Дулаан шарын гол" төрийн өмчит хувьцаат компанийн
үндсэн хөрөнгөд бүртгэх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглал тад орсон он	Хэмж их нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Балансын үнэ /төгрөг/	Хуримтлагд сан элэгдэл /төгрөг/	Үлдэгдэл үнэ /төгрөг/
1	Спектрофотометр	2018	ш	1	13,360,000.00	13,360,000.00	0.00	13,360,000.00
2	Техник жин	2018	ш	1	2,350,000.00	2,350,000.00	0.00	2,350,000.00
3	Хатаах шүүгээ	2018	ш	1	1,570,000.00	1,570,000.00	0.00	1,570,000.00
4	РН метр	2018	ш	1	4,880,000.00	4,880,000.00	0.00	4,880,000.00
5	Усан ванн	2018	ш	1	425,000.00	425,000.00	0.00	425,000.00
6	Вакуум насос	2018	ш	1	745,000.00	745,000.00	0.00	745,000.00
7	Шүүх төхөөрөмж шилний хамт	2018	ш	1	765,000.00	765,000.00	0.00	765,000.00
8	Автоклав B class	2018	ш	1	3,225,000.00	3,225,000.00	0.00	3,225,000.00
9	Автоклав DSX-280A	2018	ш	1	685,000.00	685,000.00	0.00	685,000.00
10	Өсгөврийн хөргөгч /хөлдөөгч/	2018	ш	1	3,100,000.00	3,100,000.00	0.00	3,100,000.00
11	Ус нэрэгч 5л	2018	ш	1	1,100,000.00	1,100,000.00	0.00	1,100,000.00
12	Лабораторийн ширээ	2018	ш	1	2,800,000.00	2,800,000.00	0.00	2,800,000.00
13	Химийн бодис хадгалах шүүгээ	2018	ш	1	325,000.00	325,000.00	0.00	325,000.00
14	Микроскоп	2018	ш	1	2,580,000.00	2,580,000.00	0.00	2,580,000.00
15	Термостат	2018	ш	1	945,000.00	945,000.00	0.00	945,000.00
16	Татах шүүгээ	2018	ш	1	5,200,000.00	5,200,000.00	0.00	5,200,000.00
	Нийт дүн			16	44,055,000.00 (дөчин дөрвөн сая тавин таван мянган)	44,055,000.00 (дөчин дөрвөн сая тавин таван мянган)	-	44,055,000.00 (дөчин дөрвөн сая тавин таван мянган)